

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2025/16/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.open.audit.mn Архангай аймаг 2025 он	Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ Утас: 99210906 Цахим хаяг: Tsogerdeneeg@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.5.3 Нэмэлт төсөв	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5.1 Албан шаардлага	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БГАҮТХ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДГ	Нийгмийн даатгалын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

АРХАНГАЙ АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ГЭРЭЛЧИМЭГ

2025.02.20 № 30
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь Нийгмийн даатгал хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, өмгөөлөл, хуулийн зөвлөхийн хөлс, зөвлөл хороо комиссын гишүүд, хуульд заасан үндэслэлээр албан хаагчдад олгох тэтгэмж, бусад тусламж гэсэн 6 арга хэмжээг хэрэгжүүлэх 1,653,376.5 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэл 96.0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны цалин, шимтгэлийн зардлаас 47,832.8 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 5,766.4 мянга, хангамж, бараа материалын зардлаас 1,152.7 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 1,964.5 мянга, бараа үйлчилгээний зардлаас 121.9 мянга, бусад урсгал шилжүүлгээс 2,042.3 мянга нийт 66,000.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 үндсэн зорилтын хүрээнд 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 23 арга хэмжээг 96-100 хувь, 7 арга хэмжээг 91-95 хувь, 12 арга хэмжээг 85-90 хувь, 10 арга хэмжээг 70-84 хувь, 1 арга хэмжээг үнэлэх боломжгүй байдлаар тооцож, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг Нийгмийн даатгалын ерөнхий газраас 83.6 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,857,981.00	10,516,286.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,857,981.00	10,516,286.00
35400	Хангамжийн материал	1,857,981.00	10,516,286.00
35410	Бичиг хэргийн материал	-	1,555,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	7,422,400.00
35470	Бусад хангамжийн материал	1,857,981.00	1,538,886.00
3695	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	772,085,622.01	753,337,125.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	772,085,622.01	753,337,125.84
39200	Биет хөрөнгө	756,905,622.01	738,157,125.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	705,830,409.04	705,830,409.04
39202	Хуримтлагдсан элэгдэл	(58,841,941.41)	(70,611,091.77)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,176,800.00	14,176,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(4,331,799.86)	(6,694,599.86)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	167,897,867.58	149,977,424.58
39206	Хуримтлагдсан элэгдэл	(81,607,865.11)	(66,249,626.63)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	60,790,915.80	57,253,489.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(47,008,764.03)	(45,525,678.92)
39300	Биет бус хөрөнгө	15,180,000.00	15,180,000.00
39301	Программ хангамж	2,873,407.00	2,873,407.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,873,407.00)	(2,873,407.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	15,180,000.00	15,180,000.00
395	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	773,943,603.01	763,853,411.84
50	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	773,943,603.01	763,853,411.84
51	Засгийн газрын хувь оролцоо	773,943,603.01	763,853,411.84
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	224,570,866.27	224,570,866.27
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	224,570,866.27	224,570,866.27
51200	Хуримтлагдсан үр дүн	548,758,583.16	538,668,391.99
51210	Өмнөх үеийн үр дүн	548,758,583.16	548,758,583.16
51220	Тайлант үеийн үр дүн	-	(10,090,191.17)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	614,153.58	614,153.58
60	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	773,943,603.01	763,853,411.84

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,269,715,102.98	1,758,689,403.37
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,647,750.98	20,491,698.00
3	Нийтлэг татварын бус орлого	15,647,750.98	20,491,698.00
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,647,750.98	20,491,698.00
5	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	15,647,750.98	19,201,698.00
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	1,290,000.00
7	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,254,067,352.00	1,738,197,705.37
8	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	84,821,205.37
9	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	84,821,205.37
10	Төсвийн захирагчдаас	4,229,552.00	1,653,376,500.00
11	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,653,376,500.00
12	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,229,552.00	-
13	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,249,837,800.00	-
14	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,249,837,800.00	-
15	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,294,834,033.29	1,768,779,594.54
16	УРСГАЛ ЗАРДАЛ	1,294,834,033.29	1,768,779,594.54
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,144,978,664.34	1,549,187,598.89
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	897,842,765.44	1,262,424,244.48
19	Үндсэн цалин	537,849,222.44	725,891,539.98
20	Нэмэгдэл	241,587,532.37	377,208,119.21
21	Унаа хоолны хөнгөлөлт	42,144,762.49	48,951,187.43
22	Урамшуулал	76,261,248.14	110,373,397.86
23	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,689,348.77	156,594,283.18
24	Тэтгэврийн даатгал	77,908,389.97	106,726,826.15
25	Тэтгэмжийн даатгал	8,583,389.28	12,476,603.05
26	ҮОМШӨ-ний даатгал	6,811,328.05	6,276,549.24
27	Ажилгүйдлийн даатгал	1,638,830.30	6,196,759.95
28	Эрүүл мэндийн даатгал	16,747,411.17	24,917,544.79
29	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,517,991.40	33,068,021.24
30	Гэрэл, цахилгаан	18,978,078.40	19,452,680.88
31	Түлш, халаалт	12,681,009.00	12,681,008.00
32	Цэвэр, бохир ус	858,904.00	934,332.36
33	Хангамж, бараа материалын зардал	40,153,626.40	17,864,768.82
34	Бичиг хэрэг	13,603,000.00	7,720,000.00
35	Тээвэр, шатахуун	3,984,150.00	1,526,900.00
36	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,663,909.40	3,039,491.82
37	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	243,810.00	249,400.00
38	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,902,357.00	5,328,977.00
39	Бараа материал акталсны зардал	756,400.00	-
40	Эд хогшил, урсгал засварын зардал	5,076,130.00	4,822,320.00
41	Багаж, техник, хэрэгсэл	1,402,030.00	1,626,700.00
42	Урсгал засвар	3,674,100.00	3,195,620.00
43	Томилолт, зочны зардал	9,244,600.00	17,694,400.00
44	Дотоод албан томилолт	9,244,600.00	17,694,400.00
45	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,113,218.04	3,118,197.00
46	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,790,000.00	781,900.00
47	Даатгалын үйлчилгээ	800,000.00	784,800.00

Архангай аймгийн НДГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

48	Тээврийн хэрэгслийн татвар	126,280.04	49,262.00
49	Газрын төлбөр	23,940.00	41,940.00
50	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	216,249.00	393,200.00
51	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,156,749.00	1,067,095.00
52	Бараа үйлчилгээний бусад зардал	41,340,984.29	53,601,364.17
53	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	147,500.00	5,701,970.00
54	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,193,484.29	47,899,394.17
55	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	149,855,368.95	219,591,995.65
56	Бусад урсгал шилжүүлэг	39,070,600.00	153,591,205.00
57	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,639,100.00	8,619,265.00
58	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,431,500.00	-
59	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	144,971,940.00
60	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	66,000,790.65
61	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	66,000,790.65
62	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	110,784,768.95	-
63	Төвлөрүүлэх шилжүүлэг	110,784,768.95	-
64	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (I)-(II)	(25,118,930.31)	(10,090,191.17)
65	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(25,118,930.31)	(10,090,191.17)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	1,323,221,633.72	1,738,197,705.37
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	73,383,833.72	-
3	Нийтлэг татварын бус орлого	73,383,833.72	-
4	Бусад орлого	73,383,833.72	-
5	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,249,837,800.00	1,738,197,705.37
6	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	84,821,205.37
7	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	84,821,205.37
8	Төсвийн захирагчдаас	-	1,653,376,500.00
9	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,653,376,500.00
10	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,249,837,800.00	-
11	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,249,837,800.00	-
12	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,319,508,854.74	1,728,248,505.37
13	УРСГАЛ ЗАРДАЛ	1,319,508,854.74	1,728,248,505.37
14	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,173,366,264.77	1,508,656,509.72
15	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	897,842,765.44	1,262,424,244.48
16	Үндсэн цалин	537,849,222.44	725,891,539.98
17	Нэмэгдэл	241,587,532.37	377,208,119.21
18	Унаа хоолны хөнгөлөлт	42,144,762.49	48,951,187.43
19	Урамшуулал	76,261,248.14	110,373,397.86
20	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,689,348.77	156,594,283.18
21	Тэтгэврийн даатгал	77,908,389.97	106,726,826.15

Архангай аймгийн НДГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

22	Тэтгэмжийн даатгал	8,583,389.28	12,476,603.05
23	ҮОМШӨ-ний даатгал	6,811,328.05	6,276,549.24
24	Ажилгүйдлийн даатгал	1,638,830.30	6,196,759.95
25	Эрүүл мэндийн даатгал	16,747,411.17	24,917,544.79
26	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,517,991.40	33,068,021.24
27	Гэрэл, цахилгаан	18,978,078.40	19,452,680.88
28	Түлш, халаалт	12,681,009.00	12,681,008.00
29	Цэвэр, бохир ус	858,904.00	934,332.36
30	Хангамж, бараа материалын зардал	37,507,626.40	19,419,768.82
31	Бичиг хэрэг	11,713,400.00	9,275,000.00
32	Тээвэр, шатахуун	3,984,150.00	1,526,900.00
33	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,663,909.40	3,039,491.82
34	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	243,810.00	249,400.00
35	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,902,357.00	5,328,977.00
36	Эд хогшил, урсгал засварын зардал	5,076,130.00	11,702,720.00
37	Багаж, техник, хэрэгсэл	1,402,030.00	8,507,100.00
38	Урсгал засвар	3,674,100.00	3,195,620.00
39	Томилолт, зочны зардал	9,244,600.00	17,694,400.00
40	Дотоод албан томилолт	9,244,600.00	17,694,400.00
41	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,956,469.04	2,051,102.00
42	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,790,000.00	781,900.00
43	Даатгалын үйлчилгээ	800,000.00	784,800.00
44	Тээврийн хэрэгслийн татвар	126,280.04	49,262.00
45	Газрын төлбөр	23,940.00	41,940.00
46	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	216,249.00	393,200.00
47	Бараа үйлчилгээний бусад зардал	73,531,333.72	5,701,970.00
48	Бараа үйлчилгээний бусад зардал	73,383,833.72	-
49	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	147,500.00	5,701,970.00
50	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	146,142,589.97	219,591,995.65
51	Бусад урсгал шилжүүлэг	39,070,600.00	153,591,205.00
52	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,639,100.00	8,619,265.00
53	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,431,500.00	-
54	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	144,971,940.00
55	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	66,000,790.65
56	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	66,000,790.65
57	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	107,071,989.97	-
58	Төвлөрүүлэх шилжүүлэг	107,071,989.97	-
59	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	3,712,778.98	9,949,200.00
60	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ	-	9,949,200.00
61	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	9,949,200.00
62	Дотоод эх үүсвэрээр	-	9,949,200.00
63	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	9,949,200.00

Архангай аймгийн НДГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

64	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(9,949,200.00)
65	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	3,712,778.98	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 01-р сарын 01-нээрх эхний үлдэгдэл	224,570,866.27	614,153.58	574,311,265.47	799,496,285.32
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	224,570,866.27	614,153.58	574,311,265.47	799,496,285.32
3	Тайлант үеийн үр дүн	-	-	(25,552,682.31)	(25,552,682.31)
4	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	224,570,866.27	614,153.58	548,758,583.16	773,943,603.01
5	2024 оны 01-р сарын 01-нээрх эхний үлдэгдэл	224,570,866.27	614,153.58	548,758,583.16	773,943,603.01
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	224,570,866.27	614,153.58	548,758,583.16	773,943,603.01
7	Тайлант үеийн үр дүн	-	-	(10,090,191.17)	(10,090,191.17)
8	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	224,570,866.27	614,153.58	538,668,391.99	763,853,411.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,653,376,500.00	1,587,375,709.35	66,000,790.65	96.01
2	УРСГАЛ ЗАРДАЛ	1,653,376,500.00	1,587,375,709.35	66,000,790.65	96.01
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,497,743,000.00	1,433,784,504.35	63,958,495.65	95.73
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,235,589,000.00	1,187,756,146.29	47,832,853.71	96.13
5	Үндсэн цалин	696,064,500.00	725,891,539.98	(29,827,039.98)	104.29
6	Нэмэгдэл	321,529,400.00	302,540,021.02	18,989,378.98	94.09
7	Унаа хоолны хөнгөлөлт	68,644,400.00	48,951,187.43	19,693,212.57	71.31
8	Урамшуулал	149,350,700.00	110,373,397.86	38,977,302.14	73.90
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	154,336,200.00	147,278,176.00	7,058,024.00	95.43
10	Тэтгэврийн даатгал	104,912,500.00	100,403,978.65	4,508,521.35	95.70
11	Тэтгэмжийн даатгал	12,355,900.00	11,722,156.82	633,743.18	94.87
12	ҮОМШӨ-ний даатгал	6,178,000.00	5,877,128.33	300,871.67	95.13
13	Ажилгүйдлийн даатгал	6,178,000.00	5,821,997.04	356,002.96	94.24
14	Эрүүл мэндийн даатгал	24,711,800.00	23,452,915.16	1,258,884.84	94.91
15	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,834,400.00	33,068,021.24	5,766,378.76	85.15
16	Гэрэл, цахилгаан	24,072,400.00	19,452,680.88	4,619,719.12	80.81

**Архангай аймгийн НДГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан**

17	Түлш, халаалт	13,189,600.00	12,681,008.00	508,592.00	96.14
18	Цэвэр, бохир ус	1,572,400.00	934,332.36	638,067.64	59.42
19	Хангамж, бараа материалын зардал	20,572,500.00	19,419,768.82	1,152,731.18	94.40
20	Бичиг хэрэг	9,275,000.00	9,275,000.00	-	100.00
21	Тээвэр, шатахуун	2,500,000.00	1,526,900.00	973,100.00	61.08
22	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,218,200.00	3,039,491.82	178,708.18	94.45
23	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	249,400.00	249,400.00	-	100.00
24	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,329,900.00	5,328,977.00	923.00	99.98
25	Эд хогшил, урсгал засварын зардал	21,656,300.00	21,651,920.00	4,380.00	99.98
26	Багаж, техник, хэрэгсэл	18,456,300.00	18,456,300.00	-	100.00
27	Урсгал засвар	3,200,000.00	3,195,620.00	4,380.00	99.86
28	Томилолт, зочны зардал	16,915,100.00	16,857,400.00	57,700.00	99.66
29	Дотоод албан томилолт	16,915,100.00	16,857,400.00	57,700.00	99.66
30	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,015,600.00	2,051,102.00	1,964,498.00	51.08
31	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,592,400.00	781,900.00	1,810,500.00	30.16
32	Даатгалын үйлчилгээ	784,800.00	784,800.00	-	100.00
33	Тээврийн хэрэгслийн татвар	196,200.00	49,262.00	146,938.00	25.11
34	Газрын төлбөр	49,000.00	41,940.00	7,060.00	85.59
35	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	393,200.00	393,200.00	-	100.00
36	Бараа үйлчилгээний бусад зардал	5,823,900.00	5,701,970.00	121,930.00	97.91
37	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,823,900.00	5,701,970.00	121,930.00	97.91
38	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	155,633,500.00	153,591,205.00	2,042,295.00	98.69
39	Бусад урсгал шилжүүлэг	155,633,500.00	153,591,205.00	2,042,295.00	98.69
40	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,660,300.00	8,619,265.00	2,041,035.00	80.85
41	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	144,973,200.00	144,971,940.00	1,260.00	100.00
42	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,653,376,500.00	1,587,375,709.35	66,000,790.65	96.01
43	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,653,376,500.00	1,587,375,709.35	66,000,790.65	96.01
44	Улсын төсвөөс санхүүжих	1,653,376,500.00	1,587,375,709.35	66,000,790.65	96.01
45	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	89.00	77.00	12.00	86.52
46	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
47	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
48	АЖИЛЛАГСДЫН ТОО	44.00	38.00	6.00	86.36
49	Удирдах ажилтан	4.00	1.00	3.00	25.00
50	Гүйцэтгэх ажилтан	37.00	34.00	3.00	91.89
51	Үйлчлэх ажилтан	3.00	3.00	-	100.00
52	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	44.00	38.00	6.00	86.36
53	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	38.00	34.00	4.00	89.47
54	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6.00	4.00	2.00	66.67

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	ТАЙЛАНТ ОН
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	84,821,205.37
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	84,821,205.37
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	84,821,205.37

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	84,821,205.37
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	84,821,205.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	84,821,205.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	84,821,205.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	74,668,098.19
210102	Нэмэгдэл	74,668,098.19
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,316,107.18
210201	Тэтгэврийн даатгал	6,322,847.50
210202	Тэтгэмжийн даатгал	754,446.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	399,420.91
210204	Ажилгүйдлийн даатгал	374,762.91
210205	Эрүүл мэндийн даатгал	1,464,629.63
2107	Томилолт, зочны зардал	837,000.00
210702	Дотоод албан томилолт	837,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн хүрээнд заасан зарчим, 37 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант онд НДГ нь “2030 он гэхэд бүх нийтийн насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц чадамжтай, нийгмийн даатгалын цогц үйлчилгээ бүхий даатгагч болно” гэсэн хэтийн зорилгыг дэвшүүлж ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Архангай аймгийн Нийгмийн даатгалын газар нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын харьяа төсвийн байгууллага бөгөөд үйл ажиллагаагаа Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн хүрээнд явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын ерөнхий хууль -2024.06.05
- Төсвийн тухай хууль -2024.01.12, 2024.04.19, 2024.05.16, 2024.06.05, 2024.07.10, 2024.12.03
- Төрийн хэмнэлтийн тухай хууль -2024.01.17, 2024.12.12
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль -2024.01.12, 2024.06.05, 2024.12.12
- Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай ЗГ-ын 2024.03.27-ны 128 дугаар тогтоол
- “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам” Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 82 дугаар тогтоол
- “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” Засгийн Газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоол

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт үр нөлөөтэй байна.

Тайлант онд НДЕГ болон бусад хяналтын байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн НДГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Архангай аймгийн НДГ нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн бөгөөд тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос (10,090.2) мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	4
Бараа материал	1,857.90	10,516.30	8,658.40	466.03
Үндсэн хөрөнгө	772,085.70	753,337.10	(18,748.60)	(2.43)
Нийт хөрөнгө	773,943.60	763,853.40	(10,090.20)	(1.30)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	773,943.60	763,853.40	(10,090.20)	(1.30)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	773,943.60	763,853.40	(10,090.20)	(1.30)

Хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 4.6 дахин өссөн байна.

Бараа материалын данс нь 1,857.9 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 25,097.8 мянга, НДЕГ-аас үнэ төлбөргүй шилжиж ирсэн 1,290.0 мянга нийт 26,387.8 нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 17,729.6 мянган төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 10,516.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант онд байгууллагын дохиолол хамгаалалт, камержуулах төхөөрөмжийг 6,829.6 мянган төгрөгөөр худалдан авч аж ахуйн материалд тусгаж бүртгэсэнтэй холбоотойгоор өссөн байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 2.4 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 772,085.7 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд аймгийн ОНӨГ-ын 2024.12.26-ны 676 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвшөөрлийн дагуу төсвийн хөрөнгөөр худалдан авсан 9,949.2 мянга, ТӨБЗГ-ын 2025.01.09-ны өдрийн 11 дүгээр тогтоолын дагуу элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож 19,201.7 мянган төгрөгөөр бүртгэсэн нийт 29,150.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, элэгдлийн зардал 47,899.4 мянган төгрөгөөр буурч 753,337.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант хугацаанд ТӨБЗГ-ын 2025.01.09-ны өдрийн 11 дүгээр тогтоолын дагуу элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг 50,608.7 мянган дансны үнэ бүхий үндсэн хөрөнгийг данснаас хасаж үнийг шинэчлэн тогтоосон байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант хугацааны үр дүнг (10,090.2) мянган төгрөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,505,650.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, НДЕГ-т хүргүүлжээ.

Төсвийн төслийн саналаас 15,124.5 мянган төгрөгөөр бууруулан зардлыг анх 1,490,525.8 мянган төгрөгөөр баталжээ.

Тайлант онд батлагдсан төсөвт 7 удаа тодотгол хийгдсэн байна. 2024 оны 12 дугаар сарын тодотголоор цалин, хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг нийт 52,890.0 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2,593.4, хангамж бараа материалын зардлыг 2,919.0 мянга, Эд хогшил, урсгал засварын зардлыг 18,277.6 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг 82,817.0 мянга нийт 162,850.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,653,376.5 мянган төгрөгийг тодотголоор баталжээ. Энэ нь Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай МУЗГ-ын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын дагуу үндсэн цалин хөлсийг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,653,376.5 мянган төгрөгийн төсөв баталсан.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,587,375.6 мянган төгрөг буюу 96.0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны цалин, шимтгэлийн зардлаас 47,832.8 мянга, Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 5,766.4 мянга, хангамж, бараа материалын зардлаас 1,152.7 мянга, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 1,964.5 мянга, бараа үйлчилгээний зардлаас 121.9 мянга, Бусад урсгал шилжүүлгээс 2,042.3 мянга нийт 66,000.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				төгрөгөөр	
№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	71901-Нийгмийн даатгал	1,653,376.50	1,587,375.60	66,000.90	96.01
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	1,423,065.50	1,392,170.70	30,894.80	97.83
1.2	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	144,973.20	144,971.90	1.30	100.00
1.3	80213-Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн хөлс	392.40	322.00	70.40	82.06
1.4	80224- Зөвлөл хороо комиссын гишүүд	74,285.10	41,291.80	32,993.30	55.59
1.5	80813-Хуульд заасан үндэслэлээр албан хаагчдад олгох тэтгэмж	2,256.30	1,892.70	363.60	83.89
1.6	80820-Бусад тусламж	8,404.00	6,726.50	1,677.50	80.04

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын 2024 онд нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Засаг даргын 2024.02.20-ны өдрийн Б/14 дүгээр захирамжийн дагуу албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийн 20 хувь зориулж 85,102.6 мянга, НДЕГ-аас 837.0 мянга нийт 85,939.6 мянган төгрөгийн санхүүжилт ирсэн ба гүйцэтгэлээр 99.6 хувь буюу 84,821.2 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 1,118.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Архангай аймгийн НДХ нь 2024 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.5. Худалдан авах ажиллагааны талаар

Тус байгууллагын 2024 оны батлагдсан төсвийн Эд хогшил, урсгал засварын зардлаас 9,949.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авахаар Пи Си Мойл ХХК-тай шууд гэрээг байгуулж гүйцэтгүүлсэн байна.

3.5.6. Ерөнхий чиглэлийн судалгааны талаар

- Тус байгууллага нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээрийн зүйлийн 14.7-д заасны дагуу ахмадын сангүй ба үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас ахмадын сантай холбоотой зарлага гаргаагүй байна.
- Тус байгууллага нь 2024 онд батлагдсан орон тоо 44, гүйцэтгэлээр 40 буюу төрийн захиргааны 35, төрийн үйлчилгээний 5 орон тоотой ажилласан ба байгууллагын дарга, Эрдэнэмандал, Өлзийт сумын Нийгмийн даатгалын байцаагч, үйл ажиллагааны нягтлан бодогч зэрэг 4 орон тоо сул байна. Тайлант онд Нийгмийн даатгалын газрын даргын 2024.02.14-ны 01/118, 2024.02.21-ны өдрийн 01/148, 2024.07.08-ны өдрийн 01/585, 2024.09.13-ны өдрийн 01/689, 2024.11.27-ны өдрийн 01/799, 2024.12.03-ны өдрийн 01/809 дугаар тус тус албан бичгээр сул орон тооны захиалгыг хүргүүлж ажилласан байна.
- Тайлант онд багаж техник хэрэгсэл, урсгал зардлын данснаас 10,000.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж хөрөнгө бэлтгэсэнд судалгаагаар гаргуулан авч нэгтгэв.
- Тус байгууллагын 2024 оны тодотгосон төсөвт 210801 бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 2,592.4 мянган төгрөг батлагдсан ба гүйцэтгэлээр 781.9 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 1,810.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэнд ерөнхий чиглэлээр судалгаагаар гаргуулан авч нэгтгэв.
- Мөн нэмэлтээр шатахуун зарцуулалт, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны дэмжлэгийг судалгаагаар гаргуулан авч нэгтгэл хийлээ.

Ерөнхий чиглэлийн судалгааг ажлын баримтад хавсаргав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн НДГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар хэрэгжүүлсэн.

Архангай аймгийн НДГ нь 2024 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/52 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны тодотголоор батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 1,653,376.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу **24,800.6** мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын **75** хувиар буюу **18,600.5** мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Монгол Улсын Их Хурлаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-нд баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах эрх бүхий байгууллага нь төрийн аудитын байгууллага байна гэж заасан. Энэ хүрээнд МУЕА-ын 2022 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”, 2022 оны 11 дүгээр сарын 25-ны А/89 дүгээр тушаалаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг тус тус баталсны дагуу Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хянаж ажилласан болно.

Тус байгууллага нь цалин, шимтгэлийн зардал болон бусад зардлуудаас нийт 66,000.9 мянган төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Архангай аймгийн НДГ нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 165 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын урьдчилсан болон төлөвлөх шатны ажлыг fas.audit.mn системд 2024 оны 09 сарын 13-аас 2024 оны 11 дүгээр сарын 25-ны хооронд хийж гүйцэтгэсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар залруулагдаагүй нийт 32,599.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 2 албан шаардлага хүргүүлж биелэлтийг бүрэн хангуулан fas системээр үнэлсэн байна. Үүнд:

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	32,599.0	2	32,599.0	100
Нийт дүн	2	32,599.0	2	32,599.0	100

Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар гэрээт ажилтны цалинд 31,674.5 мянга, цалингийн сангаас тэтгэмж урамшуулалд 924.4 мянга нийт 32,599.0 мянган төгрөгийг зориулалт ббус зарцуулсан зэрэг зөрчилд албан шаардлага хүргүүлэн биелэлтийг хангасан ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Архангай аймгийн Нийгмийн даатгалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн Б/108 дугаар тушаалаар томилсон бөгөөд сул орон тоог Төрийн албаны тухай хуульд заасан журмын дагуу нөхөх арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлаас өндөр дүнгээр хэмнэлт үүссэн ажиглагдаж байгаа тул дараагийн аудитаар сул орон тоо, цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал, албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг нарийвчлан шалгана.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй, харин 17,182.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар илэрсэн залруулагдаагүй 2 зөрчилтэй асуудлын материаллаг дүн нь 17,182.0 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 18,600.5 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

[illegible]

Архангай аймгийн НДГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Дүн												
-----	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Зориулалт бус зарцуулсан	1	4,501.0			1	4,501.0						
төрийн өмчийн ашиглалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллаагүй	1	12,681.0					1	12,681.0				
Дүн	1	17,182.0			1	4,501.0	1	128681.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
НДГ	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
НДГ	0	0	0	0	0	0	0	0